

АГВААНДАНДАРЫН “ХҮНИЙ НОМЫН БАЯР ХУРИМ” ЗОХИОЛЫН ТУХАЙ

М.Золзаяа - ШУА-ийн ФСЭЗХ-ийн ЭША, доктор

Түлхүүр үг: өөрийгөө шинжих, хатуужил, гэвчээр, атхаг, сэтгэлийн хир

Товч утга: Монголын сэтгэгчид буддын ёс зүйг уламжлан авч, түүнийг цаашид хөгжүүлэхэд их хувь нэмэр оруулжээ. Тухайлбал, Агваандандар /1759-1840/ 72 настайдаа “Хүний номын баяр хурим” хэмээх сургаалын зохиол туурвижээ. Энэ нь түүний учир шалтгааны ухааны бүтээлтэй салшгүй холбоотой байна. Зохиогч “Бурханы шашинд үйлдлэгэ дэмжээ болохын тулд Бодь мөрийн зэрэг, Тогмарложон, Субашид, Мүтэлпрэнва бүтээлүүдээс эш санаа авч даруйхандаа мэдэх бэрх мэдлийг өөрөө урлалгүй, ихэнхийг түүгээд бүтээв” хэмээн ямар зохиол бүтээлээс уламжлан авснаа товч тодорхойлжээ.

Монголын буддизмын ном зохиолын өв сангийн орчуулгаас олдохын хэрээр танилцаж яваа надад Агваандандарын “Хүний номын баяр хурим” хэмээх 0,8 х.х сургаалын шүлэг нь гүн утга, үзэл санаа, үндэслэл, нотолгоо, бичлэг найруулгаараа өөрийн эрхгүй бишрэл төрүүлж байлаа. Энэхүү зохиол надад ахдаж буйг мэдэрсэн атал зориг мохолгүй бичихийг оролдолхийлсэн нь алдаа мөн, бусыг мэргэн уншигч Та болгооно биз ээ.

Буддизм танин мэдэхүй, сэтгэл зүй, ёс зүйн асуудлыг харилцан шүтэлцээнд нь авч үздэг уламжлалтай. Агваандандар танин мэдэхүйн үзэл баримтлал хийгээд ёс суртахууны үзэгдлийг илт ба даган үлэхүй мэдлэгээр тайлбарлаж буй нь уг зохиолын үнэ цэнийг тодорхойлох юм. Энэхүү зохиол нь өөрийгөө сайрхан, бусдад өөрийн үзлийг шууд тулган хүлээлгэх зэргийг гэвчээс зохистойг өгүүлэн эхэлжээ. Өөрөөр хэлбэл, би-г дээдлэх үзлээс ангид байх хийгээд өөрийгөө танин мэдэх нь ёс суртахууны үүрэг болох юм. Тухайлбал,

Гайхуулан эрдмээ бүү хөөрлө дотроо нууж үйлд

Гагц өөрийн гэмийг шинжилснээс бусдаар сонжихуйг цээрлэ

Гайхан бусдын гэмийг бүү хэл нуухын арганд шамд

Гайхал өөрт сэтгэл жигших байваас түүнээс сайн... болно.

Өөрийгөө танин мэдэх гэдэг нь явдал үйлээ зөв зохион байгуулах ухаан, үйлийн үрийг цаг ямгт бодон шинжиж явахын сэрэмж юм. Өөрийгөө шинжихдээ ямагт харьцангуйгаар түгээмэл чанарын үүднээс хандахгүй аваас зовлон үүсгэх нэгэн шалтгааныг төрүүлдэг. Өөрийгөө танин мэдсэн хүн өрөөл бусдын давуу сайн талд атаархан, эн зэрэгцэх гэхээс урьтаж бусдаас суралцахыг эрхэмд үздэг тухай ч үлгэрлэн бичжээ. Мөн хэлсэн ярьсандаа эзэн болдоггүй хариуцлагагүй байдал нь

Даамай суурам сэрэмж нь үйлдлээ гэгч засдаг үгээр

Дамжижхаана ч хүрэхгүй хуурын дуун адил

Дагнан маргааш нөгөөдөр гэгч аажимлаг залхуурсны хамжаа.. гэжээ.

Буддын сургаалд өргөн мэдлэгтэй хүнийг тодорхойлохдоо аливаа бэрхшээлийг даван туулах сэтгэлийн төрөлхийн ерөнхий хүч тэнхээ, сэтгэлийн төрөлхийн хиргүй ариун ерөнхий байдлыг гол палгуур болгон авч үздэг ба энэ чадвар нь юмс үзэгдлийн мөн чанарыг үнэмлэхүй үнэний үүднээс ухаарах танин мэдэхүйн үйл явцтай давхцдаг, харин сэтгэл ухаанаа чанарын дээд төвшинд дадлагажуулан заншуулах бясалгал үйл ажиллагаанд нисванис оролдоггүй учраас сэтгэлийн хүч тамир шаардагдахгүй гэж үздэг.⁷ Тиймээс уг сургаалд

Тун ч эрдэмтнийг хүндлэх яавч хэрэгтэй

Тувтан хнжих дийлэхийг бусдад өгвөл зохино... хэмээжүхүй.

⁷ М.Гантуяа. Буддын философи судлалын зарим асуудал. УБ., 2004. 181 дэх тал.

Хариуцлагагүй түрэмгийлсэн үг яриаг дэврүүлэх, хүлээцгүй хандаж хэрүүл шуугиан хийх нь хортой үр дагавар авчирдаг тул хүлцэн тэвчихүй чухагтай. Иймээс муу үйлд хүргэх үг яриаг эерүүлэн зөөлрүүлж байхын тусад: Амьтны мууг баллан, сайныг иллэн урамтай үгээр бусдын сэтгэлийг сэргээ... гэдэг.

Монголчууд чөлөөт цагийг зөв өнгөрөөхийг сургаж, цалгар назгайг шүүмжлэн хэлэлцэж, ахуй амьжиргааны олон ажлыг нэгэн зэрэг гүйцэтгэдэг хөдөлмөрч, хичээнгүй зан чанарыг эрхэмлэдэг. Иймийн тул “ажлыг дараа хойно, нөхцөл нь тохирсон үед гэж цаг алдан хойшлуулах нь буруу гэдгийг Агваандандар: Халуун, хүйтэн цагийн байдалд тохируулан анхааран авна гэдэг хэт худал...Ялангуяа бэрх сэтгэлийн морины амыг задгай замд тэнүүлэхгүй номхотгохын арган доор хичээ” хэмээжээ.⁸ Амьдралын утга учир, хүн болж төрсний хэрэг тусыг харьцангуйгаар ойлгож:

Энэ чөлөө учралыг сайн золын эрхээр оллоо гэгч

Их зонхи нь чихний араар шуугин салхилан талийн одно... хэмээжээ. Нөгөө талаар ахуй амьдралдаа арчаа муу, залхуу хойрго хүнд өдөр тутамдаа хэрэглэх эд хөрөнгө үгүй өөрийн болон бусдын тусад өглөг өгөх нь хоцордог болно.

Нийгмийн амьдралд нийтлэг тохиолдох сэтгэл, ёс суртахууны сөрөг үзэгдэлд дадан зуршил болгож, байдаг л зүйл мэтээр хайхрамжгүйгээр үл тоомсорлох нь буруу агаад ямагт номхотгохыг хичээх нь зөв. Иймээс буруу ташаа үзлээсээ ангижрахын тулд:

Эртээс алдаж заншсан сэтгэлд **атхаг** гэтэж шургах тэргүүтнийг

Эрчимтэй нэвтэрхий мэдвээс лавлан танин барьснаас

Эгээхэн зоргоор зөнд нь хаяж орхилгүй

Идэвхлэн догшин сэтгэл жолоодох бэрхийг номхотгон даруулах эрхэм гэжээ. “Атхаг гэдэг нь эс оносон буюу үнэнээр ухаарч ойлгоогүй, гуйвуулж хазайлгасан ойлголт, эргэлзэж тээнэгэлзсэн мэдлэг” болой.⁹ Агваандандарын эл сургаалд чөлөө учралыг сайн дураар оллоо гэх, өөрөөсөө мэдлэгтэй хүнийг үл таних, ёс журмыг дууриах төдий дагах, хуурмаг сэрэмж, өөрийгөө сайн эрэмгийд тооцох зэрэг олон атхагийг өгүүлжээ.

Номхотгон даруулах гэдэг нь танин мэдэхүйн үйл ажиллагааны үр дүнд сэтгэлийн хиргүй болохыг хэлнэ. Их, бага ямар ч нүгэл үйлдсэн бай цаг зуурын мэтээр хандалгүйгээр даруухан засаж залруулахыг урьтал болгохыг

Гээгч орчлонд бяцхан тэвчин үйлдэх цаг лавтай тониллоо хэмээн

Гэмдээ аюулга үгүй шиг санаа амар сэргэлэн мэт яаж зохино буй

Гэнэтэд толгойд гал асавч түүнийг орхисноос

Гэмшин бушуу буянд шамд хэмээн... үйлийн үрээр тодорхойлжээ.

Хүний сэтгэлийн гүнд, далд ухамсарт бие биенээсээ урган гарсан нисванисын янз бүрийн шинж тэмдэг нуугдаж байдаг. Энэ нь үйлийн үрээр нэг төрлөөс нөгөө төрөлд дамжиж төрөлхийн мэт байна. Учир иймд Монголын буддизмд нисванисын таван хорын үндсийг таслан, би болон минийх хэмээн баримтлах аминч үзлийг хаахыг эн тэргүүнээ эрхэмлэдэг.¹⁰ Үүнийг Агваандандар

Далдуур хэвтсэн нисванисыг мэдэхэд бэрх

Дан илхэн болсныг анх дээрээс нь дарах бэрх хэмээн хоосныг ухаарч бодь сэтгэлээр нисванисыг дарах нь хувь хүнээс хичээнгүй чармайлт шаардахыг зохиогч хэлжээ. Төрөлхийн нисванисыг дарахын төлөө бие сэтгэлээ зориулдаг хүн сэтгэлийн хямрал, зовлонгоос төдий хэмжээгээр ангижрах учир

Даамай тэр мөнхийг нэвширтэл даран чадагч хүн түүнд

Дагт нэр цол шагнаж өндөрлүүлэн магтахад зохимж сайтай болно гэж сургасан.

⁸ Л.Хүрэлбаатар. Судар шастирын билиг. УБ., 2002. 199 дэх тал.

⁹ М.Гантуяа. Буддын философи судлалын зарим асуудал. УБ., 2004. 102 дахь тал.

¹⁰ Г.Лувсанцэрэн. Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас. УБ., 2008. 320 дахь тал.

Зохигч ёс зүйн зарим ойлголтыг тайлбарлахдаа хоосон чанарын /шуньяата/ үүднээс ханджээ. Доктор Г.Лодой “хоосон чанарын сургаалд шалтгаацилал, оршин байхуйн үүднээс юмсын мөн чанарыг зөв ойлгох аргын асуудлыг хөндөж тавьсан. Туйлшралыг давж юмсын мөн чанарыг жинхэнэ утгаар нь оносон оюун ухаан гэсэн санааг гаргадаг бололтой”¹¹ гэж үзжээ.

Тийн үзвэл ертөнцөд хэрхэн хандах вэ?, зөв амьдрал гэж юу вэ?, хэрхэн ухаалаг сонголт зийх вэ? зэрэг асуултуудад хариулахын тулд хоосон чанарт үндэслэх нь буддын ёс зүйн онцлог юм. Энэ талыг

Хоосон чанар үнэн хэт ханан мэдэж чадваас элбэг сайн баян мөн

Өрийн тун ч хайртай эдээр гүйцэх цагаар холдсонгүй хүн

Өг хогшил байвч гуйранч бодтой мөн аятай

Үгэхээр ядан зүдэж эрэн бэдрэхийн зовлонг түүгээр хийх... гэж зүйрлэсэн. Мөн хоосон чанарыг үл мэдэн биет зүйлсийг үнэхээр өөрөө бүтсэн гэж үздэгээс ёс суртахууны хийгээд өтгэл санааны доройтол, хямралд орох тул

Өг¹² эдийн хоморгонд орсноос тэмцэлдэх үед

Өрийн хар гэрчдээ чадмаар хэдийг түшвэл оньстой.... хэмээн илэрхийлжээ. Түүнчлэн зовлонг өтлэх арга зам нь хүний дотоод мөн чанарт байх ба өөрийн сэтгэлийн хатуужил, тэвчээр, юун ухааны хүчинд түшихийг номлодог буддын ёс зүйн зарчмыг онцлон үзсэн билээ. Хүн бүрт хичээл, чармайлт гаргавал амжилтанд хүрэх, ертөнцийн хүлээснээс ангижрах боломж бий. Гагцхүү тэвчээр хатуужлаас бүү ухар, ялангуяа өөрийн сэтгэлд болохгүй бүтэхгүйг урьтал болгон хоногшуулж дасгах нь саад тогтор болох учраас амьдралын идэвхитэй байр суурийг эрэлхийлэн

Мнь энэ ёзоороо бэрх хатуужлыг чадах үгүй хэмээн

Мгад сэтгэлдээ хоногшин өгөршүүлэхийг нэмэл үгүйд

Мхран дээдсийн явдал лугаа таарах нийлэхийг бодоорой.... гэж өөдрөг үзлийг номложээ. Мөн “ачийг ачаар хариулах ёс нь” бодь сэтгэлт ба хувиа хичээгчийн алин болохын ол шалгуур тул:

Үрд ачийг илүү дутуугүй хариулбаас зохимой

Эвэхэн тэр мэт бус болбоос өөрөө жигшигдэж одно... хэмээжээ.

“Сайн үйлийн төлөө хайрлах” нь хувь хүний хийгээд хамтын хамаг амьтны тусын зорилгоо үүдсэн өршөөнгүй сэтгэлээр бий болохыг:

Хмаг амьтанд туслахыг өөрөө яаж чадахаараа хий

Хрин гагц дангаараа чадах бус болбоос бусадтай хамж

• Хйртай эл өврөөс бусдыг хайрлагч заншил энэ.... гэжээ. Мөн “томоогүй хүн” хэмээх ойлголтыг тайлбарлахдаа

Твтан өртэй сайн хувцсаар гоёж өрх дараалан хэсэх

Тхай уулзсан бүгдэд танил тал гэж яаран чалчиж үйлдэх

Тхсон эмээл хазаар богцоо бусад лугаа арилжин үйлдэх... зэрэг явдал үйлээр нь шинжжээ

Алдгай тангараг өргөж хууль цаазыг сахиулагчид элдэв хээл хахууль өгч, тал тохой татах нь үйлийн үрээр эргээд ард түмэн нийтээр зовохын нэгэн шалтгаан болдгийг шүүмжлэхдээ:

Дамай өөрийн зөвийг олохын тул шийтгэгчинд

Дгах хээл өгч үйлийн үрийг хутган бүү үйлд

Дгч хэрэв хийвээс түүний андагай тангараг ч

Дгт энэ насандаа эргэх нь олонтой үзэгдэнэ ... хэмээжээ.

¹¹ Г.Лодой. Хоосон чанар /шуньяата/ хэмээх ойлголтын утгыг тайлах арга зүйн асуудалд. –Гүн ухаан нийгмийн сэтгэлгээ. №1 /12/. 38 дахь тал.

¹² бие, бодь зүйл, түүний бие эрхтний сэрэн мэдэх чадвар

Хэлээр үйлдэх нүгэлд бусдад нэр цол өгөх, тахир дүлий тэргүүтнийг элэглэх, бусдын хорыг малтан шоолон хочлох зэргийг оруулан уламжлалт тайлбарын агуулгыг дэлгэрүүлжээ. Энэ нь мэдээллийн эрх чөлөөнд дулдуйдан бусдын нэр төрийг гутаан доромжилж сэтгэл, санааны гутралд хүргэх явдал дэлгэрсэн өнөө үед ач холбогдолтой сургаал юм.

“Мэргэд гарахын орон” толь бичигт бага хөлгөний зургаан барамидын нэг нь тэвчээр (хүлцэнгүй). Энэхүү барамид нь бие, хэл, сэтгэлээр өөрийн ба бусдын хорлолт муу сэтгэлийг тэвчих сэтгэлийн дээд¹³ бөгөөд билгийн ухаанд хүрэх нэг арга. Буддын ёс зүйн өдөр тутамд мөрдөх зургаан дадлын нэг нь тэвчээр хатуужил үзүүлэх явдал учраас

Тухайлсан муугийн хариуг хариулал үгүй мартаж орхивоос сайн

Тун няхуурхан бүү ундууц, уур нь газарт амирлах аргыг хий хэмээн хураахын сацуу аливааг шийдэх арга нь зорилго биш, зорилгодоо хүрэх арга хэрэгсэл болохыг давхар хэлсэн байна. Хүний ёс суртахуунлаг амьдралын нэг зарчим нь дунджаар үзэн төлөв даруу байх явдал. Сэтгэлийн хөөрлөөр аль алиныг хэтрүүлэх нь гэмтэй. Эдгээр нь түр зуурын шинжтэйг ямагт санаж явахыг

Тувтан баярлах гомдохын урван хөрвөхөд бүү яар, төлөв сайныг шүт

Дэндүү баярлаваас хасахад хямд, гомдвол хэцүүхэн биш нь үзэсгэлэнтэй... хэмээн хэлж байна. Бидний амьдрал үйл ажиллагаа, хувь тавиланг ивээн аврагч байдаг мэтээр туйлшран үзэх нь эцсийн дүндээ би хэмээх амин хувиа хичээх үзлийг төрүүлээд зогсохгүй төөрөгдлийн шалтгаан болох сэтгэлийн гэмүүдийг үүтгэнэ. Ийм учраас ...Дээдээс ачтай мөн буй хэмээн үглэн аашлан тунихран бүү үйлд... гэжээ.

Буддизм дахь мэдлэг ухааны уламжлалт салбаруудын дотор шалгадаг ухаан хэмээх логикийн сургаал гол байр эзлэх агаад түүнийг чойрын таван ботийн нэгэн бүрдэл хэсэг, пашны сургуулиудад дараа дараагийн шатны мэдлэг ухааныг эзэмших бэлтгэл, арга ухаан буюу арга зүйн үндэс болгож судлан авч үздэг байна.

Шалгадаг ухааны гол сурвалжуудын нэг болсон Энэтхэгийн их бандида Дигнагийн “Хетучакра” зохиолыг Агваандандар “Зүгийн юмын хүрд шастрыг тодруулан үйлдэгч Их эрдэнийн зул” хэмээх шастартаа судлан тайлбарлахын зэрэгцээ “Танин мэдэхүйн ухааны ерөнхий утгын тийн сацрал” гэдэг зохиол туурвижээ.¹⁴

Дигнагийн зохиол дахь тохирох, үл тохирох харилцаан дахь өөрийн шинж, үрийн хийгээд үгүйсгэл гаргалгааны мөн чанарыг

“Хэтэрхий дээдсээр хоосон чанар ухан мэдэхэд нэн нарийхан ч

Хэт бүдүүн үзэл энэ мөнхийг шинжилснээс эвддэг,, гэсэн нотлол, батлал бодомжоор илэрхийлжээ. Хэт бүдүүн үзэл, хэт нарийн үзэл үл тохирох эсрэг харилцаанд байх ойлголтууд бөгөөд харшлахуйн нотлол гаргалгааны үндэслэгээ болдог. Энэ нь Агваандандарын онож хэлснээр эсрэг тэсрэг харшлал юм. Эсрэг, тэсрэг харшлал нь бидний хүрээлэн буй ертөнц ба хүний дотоод мөн чанарыг үнэн зөвөөр ухаарахад тусалдаг тулгуур зарчим болдог байна.

Буддизмд илтийн шалгадаг мэдэл хэмээх нь мэдэрч танин мэдэхүйг, сэтгэж танин мэдэхүйг даган үлэх шалгадаг мэдэл хэмээх нэр томъёогоор илэрхийлнэ. Илтийн шалгадаг мэдлийн үүднээс мөнх ба мөнх бусын үнэн худлыг шууд тодорхойлох боломжгүй. Иймээс,

Өөрөө орчлонг үнэхээр гяндан мэтэд таалснаас

Өнөө хяруу хайлахын төдийд орохыг сэтгэлдээ дурлах хэрэг үгүй хэмээн <<сэтгэлгээний арга барил нь аливаа тодорхой бодит юмыг нарийсган үзсээр эцэстээ маш нарийн тоосонд тулган үздэг. Маш нарийн тоос нь ухааны нигуурт ч жувь тодрол салах үндэсгүй>>¹⁵ гэдэг хийсвэрлэлийн хэлбэрээр сэтгэж танин мэдэхүйн ач холбогдлыг ч

¹³ Д.Дагвадорж. Монголын гүн ухааны уламжлалт тогтсон таалал. УБ., 1994. 28 дахь тал.

¹⁴ Т.Содномдаргиа. Дигнагийн “Есөн гаргалгааны хүрдэн” зохиол. УБ., 1998. 4-6 дахь тал.

¹⁵ Агваандандар. Оногдохуйг шинжлэхийн тайлбар үзэсгэлэнт сувдан эрх оршвой. —Гүн ухаан, нийгмийн сэтгэлгээ. //Орч Т.Содномдаргиа №1 /12/. УБ., 1992. 106 дахь тал

тодорхойлжээ. Агзаандандар мэдэрч танин мэдэхүйг бодит үнэнийг нээн харуулах хэрэгсэл, анхны шат мөн гэж үзээд, мэдрэхүйн эрхтнүүдийн гүйцэтгэх үүргийг өндөрт тавьжээ.¹⁶ Тиймээс,

Ялган салгах хэрэгт түүгээр зүйрлэн хэлэх хэл олон буй амуй ч

Яаран эхэнд нь **бүдүүнийг нь хураасан** мөн ёсыг мэдэн үйлд

Эгээхэн сэтгэлд ургасан бүгдийг **үлэл үгүй** амандаа гаргадаг үгүй... хэмээн хэл сэтгэхүйн холбоо хамаарлыг тэмдэглээд зогсохгүй танин мэдэхүйн уг сурвалж нь туршлага гэсэн санааг дэвшүүлжээ. Түүнчлэн, ёс зүйн асуудлыг сэтгэлийн шинжлэлээр үүссэн магадлалт мэдлэгэ даган үлэх буюу нотолгоо, үндэслэгээгээр баяжуулж үнэн мэдлэг гаргаж авдаг буддын логикийн аргаар илэрхийлсэн байна. “Бүдүүнийг хураасан мөн ёсыг мэд” гэдэг нь хоосон чанарыг зөв ухаарваас хэл, сэтгэхүйн шалтгаан үрийг тодорхойлоход тустайг өгүүлжээ.

Тэрээр сургаалынхаа төгсгөлд”Элдэв номын хэл айлын хэл (ярианы хэл, жишээ авсанаа хэлж буй М.З) элдвийг нийлүүлсэн магадаар, Ингээж хүчээр нийлүүлэн үргэлжлэхийн ёсонд би бээр үйлсэв”¹⁷ хэмээн зохиол бичсэн арга зүйгээ даруухнаар дурьджээ.

Эцэст нь дүгнэж хэлбэл, Дандар лхарамба хүний танин мэдэхүйг нарийвчлан авч үзэхдээ мэдлэг, сэтгэл, ёс суртахууныг нэгдэлд нь тайлбарласан. Ёс суртахууны үйлдэл, харилцаа, ухамсрын үзэгдлүүдийн хэлхээ холбоог илэрхийлэхдээ буддын танин мэдэхүйн эсрэг тэсрэг талууд бие биенээ нөхцөлдүүлэн оршдог хэмээх үзэлд үндэслэжээ. Ёс горимыг дууриах төдий дгах, хуурмаг сэрэмж, өөрийгөө үл таних нь “**атхаг**” болно. Тиймээс сэтгэлийн хиргүй болох номхотгохын аргад шүтэхийг эрхэмлэх нь зөв амьдралыг бий болгодог гэсэн үзэл санааг тус зохиолд дэвшүүлжээ.

Ном зүй

1. Гантуяа.М. Буддын философи судлалын зарим асуудал. УБ., 2004.
2. Гүн ухаан нийгмийн сэтгэлгээ. №1 /12/
3. Дагвадорж.Д. Монголын гүн ухааны уламжлалт тогтсон таалал. УБ.,1994
4. Лувсан, Үүрийнтуяа. Төвд номоор гийсэн монгол эрдэмтэд. ӨМАХХ.,1998
5. Лувсанцэрэн.Г. Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас. УБ., 2008
6. Монголын философийн түүх. Дэвтэр-4. УБ., 2001
- 7.Отгонбаяр.М. Логик. УБ., 2004
8. Содномдаргиа.Г. Дигнагийн “Есөн гаргалгааны хүрдэн” зохиол. УБ.,1998
9. Хүрэлбаатар.Л.Алтан хүрдэн. УБ.,1992
10. Хүрэлбаатар.Л. Судар шастирын билиг. УБ., 2002

¹⁶ Монголын философийн түүх. Дэв-4. УБ., 2001. 193 дахь тал.

¹⁷ Алтан хүрдэн. Хэвэлд бэлтгэсэн: Л.Хүрэлбаатар. УБ.,1992. 23 дахь тал.